



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.4-р заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6-р заалт, Удирдах зөвлөлийн 2015 оны 06-р сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2015-2016 оны хичээлийн жилийн нэг кредитийн үнэлгээг 2016 оны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын орчинг сайжруулах, хөрөнгө оруулалт, инфляцийн түвшинг харгалзан 1-р курсын бакалавр оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг 25 %-иар, бусад курсын бакалавр оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг 15%-иар тус тус нэмэгдүүлэн тогтоож, нэгдүгээр хавсралтын дагуу мөрдөхийг зөвшөөрсүгэй.
2. Магистр оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тогтоохдоо бакалавр оюутны батлагдсан нэг кредитийн үнэлгээг 1.5 коэффициентоор үржүүлж тогтоосугай.
3. Доктор оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тогтоохдоо бакалавр оюутны батлагдсан нэг кредитийн үнэлгээг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.
4. ШУТИС-д хэрэгжүүлж байгаа гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн гадаад хэл дээр заагдаж байгаа хичээлийн нэг кредитийн үнэлгээг 2015-2016 оны хичээлийн жилд мөрдөхөөр батлагдсан бакалаврын нэг кредитийн үнэлгээг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.
5. Сургалтын төлбөрийг төрөөс явуулж байгаа бодлоготой нийцүүлэн тогтоосонтой холбогдуулан Монгол Улсын 2016 оны төсвийн төсөлд ШУТИС-д зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгуулах, тус их сургуулийн хөгжилд чиглэсэн хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгуулж байх талаар идэвхи санаачлагатай ажиллахыг их сургуулийн удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.БУЯНЦОГТОО

